



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/269

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардалд 670,050 (зургаан зуун далан мянга тавь) төгрөг, шинэ жилийн баярыг тохиолдуулан удирдлагуудад хүндэтгэл үзүүлэх зардалд 246,000 (хоёр зуун дөчин зургаан мянга) төгрөг, сургалтад хамрагдсан малчдыг шагнах өргөмжлөлийн зардалд 500,000 (таван зуун мянга) төгрөг, нийт 1,416,050 (нэг сая дөрвөн зуун арван зургаан мянга тавь) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 1,416,050 (нэг сая дөрвөн зуун арван зургаан мянга тавь) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

